



**ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 07

Чингис хот

Нөөцийн сангаас нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.8, 2.3, 2.3.5, 2009 оны 99 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.1, 6.2, 6.2.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 130 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Цолмон овогтой Одгэрэлийг Галшар сумын Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн мэргэжилтний сул ажлын байранд санал болгосугай.

2. Энэхүү тогтоолыг Галшар сумын Засаг даргын Тамгын газрын дарга /У.Батсуурь/-д хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Болормаа/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР